



Долоо хоног тутмын хэвлэл  
2016 оны 05 дугаар сарын 09  
№ 19 /928/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

1389

Монгол Улсын  
хууль

1398

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1402

Органик хүнсний тухай

Сонгуулийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай

Үндсэн хуулийн цэцийн  
2016 оны 05 дугаар дүгнэлтийн  
тухай



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

462.	Органик хүнсний тухай	1389
463.	Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1398

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

464.	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 34	1400
465.	Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 38	1402
466.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 39	1402
467.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 40	1403

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

468.	“Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 141	1404
------	--	------------	------

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

### ОРГАНИК ХҮНСНИЙ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.



## **2 дугаар зүйл.Органик хүнсний тухай хууль тогтоомж**

2.1.Органик хүнсний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Хүнсний тухай хууль<sup>2</sup>, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль<sup>3</sup>, Байгалийн ургамлын тухай хууль<sup>4</sup>, Ойн тухай хууль<sup>5</sup>, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль<sup>6</sup>, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль<sup>7</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

## **3 дугаар зүйл.Хуулийн хамрах хүрээ**

3.1.Энэ хууль нь хөдөө аж ахуйн гаралтай органик хүнс болон боловсруулаагүй түүхий эд, бүтээгдэхүүн, байгалийн ургамал ашиглаж үйлдвэрлэсэн органик хүнс, мал амьтны органик тэжээл, органик бордоо, таримлын үр, суулгацад хамаарна.

3.2.Ан амьтны гаралтай түүхий эдээр органик хүнс үйлдвэрлэх, нийтийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

## **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“органик хүнс” гэж Хүнсний тухай хуулийн 3.1.5-д заасныг;

4.1.2.“органик үйлдвэрлэл” гэж энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн хөдөө аж ахуйн анхан шатны болон хүнсний боловсруулах органик үйлдвэрлэл эрхлэхийг;

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Хүнсний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Байгалийн ургамлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Ойн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 21 дугаарт нийтлэгдсэн

<sup>7</sup> Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

4.1.3.“шилжилтийн үе” гэж анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийх эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулснаас эхлэн органик үйлдвэрлэлд бүрэн шилжих хүртэл хугацааг;

4.1.4.“баталгаажуулалт” гэж Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 3.1.9-т заасныг;

4.1.5.“хувиргасан амьд организм” гэж Хувиргасан амьд организмын тухай<sup>8</sup> хуулийн 3.1.2-т заасныг.

### **5 дугаар зүйл.Органик үйлдвэрлэлийн зарчим**

5.1.Органик үйлдвэрлэлд дараахь зарчмыг баримтална:

5.1.1.хөрс, ус, агаар, ургамал, амьтан, хүн амын оршин тогтнох эрүүл аюулгүй байдлыг хамгаалсан байх;

5.1.2.органик үйлдвэрлэл экосистемд сөрөг нөлөөгүй, байгаль экологийн тогтвортой байдлыг хадгалсан байх;

5.1.3.зах зээлийн шударга өрсөлдөөнд суурилж, үйлдвэрлэлийн бүх үе шатанд шударга, энэрэнгүй ёсыг баримтлах;

5.1.4.хүрээлэн байгаа орчин, одоо болон ирээдүй хойч үеийн эрүүл мэнд, сайн сайхныг хамгаалах, бүтээгдэхүүний органик болон байгалийн шинж байдлыг хадгалахад чиглэсэн хариуцлагатай арга технологиор үйлдвэрлэл эрхлэх.

5.2.Орцын 90 болон түүнээс дээш хувь нь органик найрлагатай хүнс, тэжээл, бордоог органикт тооцно.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛ**

#### **6 дугаар зүйл.Органик үйлдвэрлэлийн шилжилтийн үе**

6.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийх эрх бүхий этгээд /цаашид “баталгаажуулалтын байгууллага” гэх/-д органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлтээ гаргана.

6.2.Баталгаажуулалтын байгууллага органик үйлдвэрлэлд шилжих шилжилтийн үеийг эхлүүлэх болон органик хүнсийг баталгаажуулах тухай

<sup>8</sup> Хувиргасан амьд организмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 29 дугаарт нийтлэгдсэн.



гэрээг үйлдвэрлэл эрхлэгчтэй байгуулснаас хойш энэ тухай ажлын 10 өдөрт багтаан хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

6.3.Баталгаажуулалтын байгууллага шилжилтийн үеийн хугацааг органик үйлдвэрлэлийн байршил, төрөл, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөлтийн байдал, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлтийг харгалзан энэ хуулийн 8.3-т заасан журмын дагуу тогтооно.

6.4.Баталгаажуулалтын байгууллага органик үйлдвэрлэлд бүрэн болон хэсэгчлэн шилжсэн, шилжиж чадаагүй талаархи үйлдвэрлэл эрхлэгчийн мэдээллийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагад ажлын 10 өдөрт багтаан бичгээр мэдэгдэнэ.

6.5.Органик хүнсний боловсруулах үйлдвэрлэл шилжилтийн үегүй байж болно.

## **7 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг**

7.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1-д зааснаас гадна дараахь үүрэг хүлээнэ:

7.1.1.баталгаажуулалтын байгууллагатай байгуулсан энэ хуулийн 6.2-т заасан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах;

7.1.2.мал, амьтан, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний байгалийн шинж чанарыг хадгалах үйлдвэрлэлийн арга технологи боловсруулж мөрдөх;

7.1.3.аж ахуйн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан, хаягдалгүй, эсхүл хаягдал багатай технологийг ашиглах, усыг зүй зохистой хэрэглэх;

7.1.4.органик үйлдвэрлэлийг бүхэлд нь, эсхүл тухайн төрлийн хүнсийг үйлдвэрлэхээ зогсоосон бол ажлын 10 өдөрт багтаан баталгаажуулалтын болон мэргэжлийн хяналтын байгууллагад бичгээр мэдэгдэх.

7.2.Органик үйлдвэрлэл эрхлэгч дараахь эрхтэй:

7.2.1.баталгаажуулалт хийлгэсэн болон шилжилтийн үеийн хүнс, тэжээл, бордооны шошгод энэ хуулийн 11.2-т заасан органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэх;



7.2.2.энэ хуулийн 8.3-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэлийг органик бус үйлдвэрлэлтэй хавсран эрхлэх;

7.2.3.нийлүүлэгчээс түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авахдаа энэ хуулийн 8.3-т заасан бодис, хувиргасан амьд организм, цацрагийн боловсруулалт, өсөлтийн даавар хэрэглээгүй болон органик болохыг тодорхойлсон баталгаа шаардах.

## **8 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавих шаардлага**

8.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

8.1.1.органик үйлдвэрлэлийн үйл явц болон органик хүнсийг хоёр жил тутамд баталгаажуулалтад хамруулах;

8.1.2.баталгаажуулалтын зардлыг хариуцах;

8.1.3.ойн дагалт баялаг болон байгалийн ургамал ашигласан тохиолдолд сүүлийн гурван жилийн туршид энэ хуулийн 8.3-т зааснаас өөр бодисоор ариутгал, халдваргүйжүүлэлт хийгээгүй талаар байгаль орчин болон хүнс, хөдөө ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон талбайгаас түүх;

8.1.4.ойн дагалт баялаг болон байгалийн ургамал түүж ашиглахдаа Ойн тухай болон Байгалийн ургамлын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг хэрэгжүүлэх.

8.2.Органик үйлдвэрлэлд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.3-т зааснаас гадна дараахь үйлдлийг хориглоно:

8.2.1.энэ хуулийн 8.3-т зааснаас бусад бодис хэрэглэх;

8.2.2.органик хүнсийг боловсруулах явцдаа цацрагийн боловсруулалт хийх;

8.2.3.айл өрх болон үйлдвэр, аж ахуйн газрын бохир, хот суурины цэвэрлэх байгууламжийн лаг ашиглах;

8.2.4.эсээр үржүүлэх /клонинг/ аргаар гарган авсан мал, амьтан, тэдгээрийн үр төл ашиглах;

8.2.5.хувиргасан амьд организм, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон өсөлтийн даавар ашиглах.



8.3.Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам, хэрэглэх бодисын жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4.Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлалыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **9 дүгээр зүйл.Органик хүнсийг импортлох, экспортлох, худалдах**

9.1.Органик хүнсийг импортлох, экспортлохтой холбогдсон харилцааг Хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйл, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйл, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 16.14.2-т заасны дагуу тус тус зохицуулна.

9.2.Экспорт болон импортын органик хүнсийг Хүнсний тухай хуулийн 16.1-д заасны дагуу хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж, мэдээллийн сан үүсгэнэ.

9.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдах импортын органик хүнс нь энэ хуулийн 9.1-д зааснаас гадна доор дурдсан шаардлага хангасан байна:

9.3.1.Хүнсний тухай хуулийн 16.2-т заасан журмын дагуу бүртгүүлж жагсаалтад орсон байх;

9.3.2.экспортлогч улсын эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаас олгосон органик болохыг тодорхойлсон хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх.

9.4.Импортлосон органик хүнсийг жижиглэн савласан тохиолдолд шошго нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.8-д заасан шаардлагыг хангана.

9.5.Мэргэжлийн хяналтын байгууллага органик хүнсийг экспортлох болон импортлох үеийн хяналт, шалгалтын мэдээг гаргаж, улирал тутам хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ОРГАНИК ХҮНСНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ,  
ШОШГОЛОЛТ, БҮРТГЭЛ**

**10 дугаар зүйл. Баталгаажуулалтын байгууллага, органик  
үйлдвэрлэл болон хүнсний баталгаажуулалт,  
бүртгэл**

10.1. Органик үйлдвэрлэлийн болон органик хүнс, тэжээл, бордооны баталгаажуулалтыг доор дурдсан байгууллага гүйцэтгэнэ:

10.1.1. Монгол Улсын эрх бүхий байгууллагаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага;

10.1.2. Монгол Улсад бүртгэлтэй, гадаад улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага.

10.2. Энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэсэн хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад тал хамтран баталгаажуулах бол хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

10.3. Энэ хуулийн 10.1-д заасан баталгаажуулалтын байгууллагыг бүртгэх журмыг үндэсний итгэмжлэлийн байгууллага, 10.2-т зааснаар баталгаажуулах тохиолдолд түүнд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.4. Баталгаажуулалтын байгууллага эрх бүхий үндэсний болон олон улсын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартын хүрээнд баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгох, мөн түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгож болох бөгөөд энэ тухай хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

10.5. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажсан органик үйлдвэрлэл, хүнсний мэдээллийн санг бүрдүүлж, тухай бүр шинэчлэн мэргэжлийн хяналтын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

10.6. Үндэсний итгэмжлэлийн болон хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээдийн талаархи мэдээллийн санг бүрдүүлж, тухай бүр шинэчлэнэ.

10.7. Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд дараахь үүрэгтэй:





10.7.1.органик үйлдвэрлэл эрхлэгчтэй энэ хуулийн 6.2-т заасан гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

10.7.2.органик үйлдвэрлэл эрхлэгч энэ хуулийн 8.2-т заасныг зөрчиж үйлдвэрлэл явуулсан бол баталгаажуулалтыг хүчингүй болгож, энэ тухай мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллага болон хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдөрт багтаан албан бичгээр мэдэгдэх;

10.7.3.эрх бүхий байгууллагыг баталгаажуулсан үйлдвэрлэл эрхлэгчийн тухай мэдээллээр хангах;

10.7.4.энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд үндэсний итгэмжлэлийн байгууллагад бүртгүүлэхгүйгээр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

### **11 дүгээр зүйл.Органик хүнсний тэмдэг, тэмдэглэгээ, шошго**

11.1.Энэ хуулийн 10.1-д зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэг, 10.2-т зааснаар баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг тус тус шошгод тавина.

11.2.Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ шилжилтийн үед шар өнгийн дэвсгэртэй, органик үйлдвэрлэлд шилжсэнээс хойш ногоон өнгийн дэвсгэртэй байна.

11.3.Органик хүнсний шошгод Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.7-д зааснаас гадна баталгаажуулалтын байгууллагын нэрийг бичиж болно.

11.4.Хүнсэн дэх органик орцын нэр, хувь хэмжээг шошгод тусгаж болно.

11.5.Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэхэд дараахь үйлдлийг хориглоно:

11.5.1.органик бус хүнс, тэжээл, бордоог органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээтэйгээр нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, зар сурталчилгаанд ашиглах;

11.5.2.шилжилтийн үед үйлдвэрлэсэн хүнс, тэжээл, бордоог ногоон өнгийн дэвсгэртэйгээр нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, зар сурталчилгаанд ашиглах.



11.6.Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.7.Хүнсний шошгод монгол болон гадаад хэлээр бичигдсэн “органик”, “байгалийн цэвэр”, “байгалийн гаралтай цэвэр” гэсэн үгийг хэрэглэх бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

## **12 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл, органик хүнсэнд тавих хяналт**

12.1.Органик үйлдвэрлэлийн сүлжээнд болон органик хүнсний хадгалалт, тээвэрлэлт, экспорт, импорт, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль<sup>9</sup>, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль<sup>10</sup>, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар тус тус зохицуулна.

12.2.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан баталгаажуулалт хийсэн этгээд органик хүнсний үйлдвэрлэлийн үйл явцад байнгын хяналт тавина.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **13 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

13.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **14 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

14.1.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

## **З.ЭНХБОЛД**

<sup>9</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>10</sup> Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 3 дугаарт нийтлэгдсэн



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 05 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Сонгуулийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 128 дугаар зүйлийн 128.3.10 дахь заалт нэмсүгэй:

#### **1/128 дугаар зүйлийн 128.3.10 дахь заалт:**

“128.3.10.сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоонд энэ хуулийн 125.2-т заасан хугацаанаас 10 хоногийн өмнө хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт.”

**2 дугаар зүйл.** Сонгуулийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2 дахь хэсгийн “гишүүнийг” гэсний дараа “тус бүр нэг мандаттай 76 тойргоос” гэж, 128 дугаар зүйлийн 128.8 дахь хэсгийн “нэр дэвшигчдийн” гэсний өмнө “нам, эвслээс” гэж, мөн хэсгийн “бүртгэх” гэсний өмнө “, бие даан нэр дэвшигчийн талаархи баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Сонгуулийн тухай хуулийн дараахь зүйл, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/7 дугаар зүйл:**

**“7 дугаар зүйл. Сонгуулийн тогтолцоо**

7.1. Сонгууль нь олонхийн /мажоритар/ тогтолцоотой байна.”

#### **2/85 дугаар зүйлийн 85.1.1 дэх заалт:**

“85.1.1.намыг Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн он, сар, өдрийг баримтлан, эвслийг түүний бүрэлдэхүүнд орсон намуудын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллын дагуу тэдгээрийн нэр дэвшигчийг;”

#### **3/126 дугаар зүйлийн 126.5.3 дахь заалт:**

“126.5.3.энэ хуулийн 126.1-д заасан нэрийн жагсаалтыг гаргахдаа энэ хуулийн 122.1, 126.4-т заасан хуралдаанаар нэр дэвшигч

бүрийн авсан саналын тоо, хувиар нь эрэмбэлэн, тойргийн дарааллын дагуу үйлдэх;”

**4 дүгээр зүйл.** Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “150-иас” гэснийг “45-аас” гэж, 36 дугаар зүйлийн 36.14.3 дахь заалтын “эвслийн” гэснийг “хамтарсан намуудын сонгуульд төлөөлөх байгууллагын” гэж, мөн зүйлийн 36.14.4 дэх заалтын “эвсэл” гэснийг “хамтарсан намуудын сонгуульд төлөөлөх байгууллага” гэж, 72 дугаар зүйлийн 72.4 дэх хэсгийн “олонхийн сонгуулийн тогтолцооны” гэснийг “сонгуульд” гэж, 92 дугаар зүйлийн 92.3 дахь хэсгийн, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийн, 99 дүгээр зүйлийн 99.2 дахь хэсгийн “нэр дэвшигч, нам, эвслийн” гэснийг “нэр дэвшигчийн” гэж, 125 дугаар зүйлийн 125.1, 125.2 дахь хэсгийн “55” гэснийг “37” гэж, 126 дугаар зүйлийн 126.2 дахь хэсгийн “30-аас” гэснийг “20-иос” гэж, 128 дугаар зүйлийн 128.2, 128.3 дахь хэсгийн “тав” гэснийг “гурав” гэж, 128 дугаар зүйлийн 128.12 дахь хэсгийн “зургаан” гэснийг “гурван” гэж, 129 дүгээр зүйлийн 129.2 дахь хэсгийн, 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсгийн “40-өөс” гэснийг “25-аас” гэж, 132 дугаар зүйлийн 132.3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын сонгууль 100 хувь олонхийн сонгуулийн тогтолцооны дагуу явагдсан бөгөөд нам, эвслийн нэр дэвшигч” гэснийг “Нэр дэвшигч” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “нам, эвсэл,” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын сонгуульд нам, эвслийн төлөө болон” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.4, 22.6, 22.7, 22.9, 22.10 дахь хэсгийн, 31 дүгээр зүйлийн 31.12, 31.13 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.11, 33.12 дахь хэсгийн, 122 дугаар зүйлийн 122.1.3.а дахь дэд заалтын, 127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсгийн, 135 дугаар зүйлийн 135.1 дэх хэсгийн “олонхийн” гэснийг, 97 дугаар зүйлийн 97.8.3, 97.8.4 дэх заалтын “, нам, эвсэл” гэснийг, 133 дугаар зүйлийн 133.2 дахь хэсгийн “/цаашид “А” жагсаалт” гэх/-ыг” болон “, мандатын тоотой тэнцүү тооны” гэснийг, мөн зүйлийн 133.3 дахь хэсгийн ““А”” гэснийг, 134 дүгээр зүйлийн гарчгийн “гаргах, суудал хуваарилах,” гэснийг, 134 дүгээр зүйлийн 134.3 дахь хэсгийн “нам, эвслийн авсан суудлын тоо” гэснийг, 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын сонгууль 100 хувь олонхийн сонгуулийн тогтолцооны дагуу явагдсан бөгөөд” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг, 72 дугаар зүйлийн 72.6, 72.7, 72.8 дахь хэсгийг, 84 дүгээр



зүйлийн 84.4, 84.6 дахь хэсгийг, 89 дүгээр зүйлийн 89.8 дахь хэсгийг, 99 дүгээр зүйлийн 99.1.4 дэх заалтыг, 120 дугаар зүйлийн 120.3, 120.4 дэх хэсгийг, 122 дугаар зүйлийн 122.1.3.б дэх дэд заалтыг, 132 дугаар зүйлийн 132.4, 132.5, 132.6 дахь хэсгийг, 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсгийг, 134 дүгээр зүйлийн 134.1 дэх хэсгийг, мөн зүйлийн 134.1.1, 134.1.2, 134.1.3, 134.1.4, 134.1.5, 134.1.6 дахь заалтыг, мөн зүйлийн 134.2 дахь хэсгийг, 137 дугаар зүйлийн 137.2, 137.3, 137.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

### **Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гамшгаас хамгаалах тухай хуулийн биелэлтийг хангах, хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг хангах чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Монгол орны болон Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилт, цаашдын төлөв байдал, аюулын үнэлгээний судалгаа болон мониторингийн ажлыг өргөжүүлж эрчимжүүлэх, томоохон хот, суурин газрын газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг хийж гүйцэтгэх;



3/газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах;

4/энэ тогтоолын 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг шилжүүлэн байрлуулах саналыг боловсруулж 2016 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

5/орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах;

6/барилга байгууламжийн хийц, бүтээц, эдлэхүүн, материал, түүхий эдийн бат бэх чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, техник технологийг туршин шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгдсэн лабораторийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллуулж, орон нутагт сүлжээ бий болгон өргөжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

7/газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;

8/"Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /М.Сономпил/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “хувь тэнцүүлсэн /пропорциональ/”, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын 48-аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно.” гэж заасны “... 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... шууд ... сонгоно.”, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар  
хот

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.“Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр тогтоолын тогтоох хэсгийн “, 16.6 дахь” гэснийг “дэх” гэж өөрчилсүгэй.

2.“Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 05 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар  
хот

### **Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай**

Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

2.Энэ тогтоолыг Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 3 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар  
хот

### **“Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйлчилгээ үзүүлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөр дамжуулан иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод, тус төвөөр дамжуулан иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээний талаарх саналаа тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байхыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгасугай.

3. “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах харьяа байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан баталж, үйл ажиллагааг нь 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор эхлүүлэх арга хэмжээ авахыг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндоржид зөвлөсүгэй.

4. Харьяа нутаг дэвсгэртээ “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” байгуулах бэлтгэл ажлыг хангаж, үйл ажиллагааг нь 2016 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, шаардагдах зардлыг 2016 оны хувьд тухайн орон нутгийн төсвөөс, цаашид холбогдох хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсөв болон Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,



энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**С.БАЯРЦОГТ**

Засгийн газрын 2016 оны 141 дүгээр  
тогтоолын хавсралт

**“ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ”-ИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөр дамжуулан төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв (цаашид “нэгдсэн төв” гэх) нь төрийн үйлчилгээг төвлөрүүлэн иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх чиг үүрэг бүхий, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх зохион байгуулалтын нэгж бөгөөд тус төвийн үйл ажиллагааг харьяа нутаг дэвсгэртээ аймаг, нийслэлийн Засаг дарга удирдан зохион байгуулна.

1.3. Нэгдсэн төв нь үйлчилгээг шуурхай, чанартай үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамж, дэд бүтцээр бүрэн хангагдсан байх бөгөөд эелдэг уур амьсгалыг бүрдүүлсэн туршлага, мэдлэг, ур чадвар, бүтээлч хандлага бүхий хариуцлагатай албан хаагч, тав тухтай, тохилог орчинг бүрдүүлсэн үйлчилгээний танхимуудтай байна.

1.4. Нэгдсэн төв нь ажлын өдрүүдэд 08.00-20.00 цаг хүртэл, Бямба гарагт 10.00-16.00 цаг хүртэл, хоёр ээлжээр тасралтгүй ажиллана.

1.5. Нэгдсэн төвийн ажиллах цагийн хуваарийг тухайн орон нутгийн онцлогийг харгалзан энэ журмын 1.4-т зааснаас өөрөөр тогтоож болно.

1.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга нэгдсэн төвөөр үзүүлж байгаа үйлчилгээний чанар, стандарт, хүртээмжид байнгын хяналт тавьж ажиллана.



1.7. Нэгдсэн төвийн угтах үйлчилгээний ажилтан, үйлчилгээний ахлах ажилтан, мэргэжилтэн, менежерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.8. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.8.1. “үйлчлүүлэгч” гэж үйлчилгээ авахаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг;

1.8.2. “хүсэлт” гэж биечлэн болон албан бичиг, утас, цахим болон бусад хэлбэрээр төрийн үйлчилгээ авахаар гаргасан үйлчлүүлэгчийн хүсэлтийг;

1.8.3. “угтах үйлчилгээний ажилтан” гэж үйлчлүүлэгчийг угтан авч, шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, үйлчилгээ авахад нь чиглүүлэх үүрэг бүхий нэгдсэн төвийн албан хаагчийг;

1.8.4. “үйлчилгээний ажилтан” гэж үйлчлүүлэгчийг хүлээн авч, шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий тухайн төрийн байгууллагын албан хаагчийг;

1.8.5. “үйлчилгээний ахлах ажилтан” гэж байгууллагын үйлчилгээний ажилтны үйл ажиллагаанд чанарын хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий албан хаагчийг;

1.8.6. “мэргэжилтэн” гэж нэгдсэн төвөөс үзүүлж байгаа үйлчилгээний хугацаанд хяналт тавих үүрэг бүхий нэгдсэн төвийн албан хаагчийг;

1.8.7. “менежер” гэж нэгдсэн төвөөс үзүүлж байгаа үйлчилгээнд стандартын хяналт тавих үүрэг бүхий аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон нэгдсэн төвийн албан хаагчийг;

1.8.8. “дэмжлэг үзүүлэх ажилтан” гэж нэгдсэн төвөөс ирүүлсэн хүсэлтийг шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, хариуг нэгдсэн төв рүү илгээх үүрэг бүхий тухайн төрийн байгууллага дээрээ ажиллаж байгаа албан хаагчийг;

1.8.9. “хүргэлтийн ажилтан” гэж нэгдсэн төв болон тухайн төрийн байгууллага хооронд шаардлагатай баримт, материалыг хүргэх, зөөвөрлөх үүрэг бүхий албан хаагчийг.



Хоёр. Нэгдсэн төвийн үйл ажиллагаанд  
баримтлах зарчим

2.1. Нэгдсэн төвийн үйл ажиллагаанд хууль тогтоомжид зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

2.1.1. “1x1” буюу нэг үйлчлүүлэгч, нэг албан хаагчтай харилцах;

2.1.2. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.1.3. төрийн байгууллагаас өгөх ёстой мэдээллийг үйлчлүүлэгчээс шаардахгүй байх;

2.1.4. үйлчлүүлэгчийн хүсэлтийг үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэх;

2.1.5. үйлчилгээг нэг дор, шуурхай, иж бүрэн хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

2.1.6. үйлчилгээний талаарх мэдээлэл, үйлчилгээний журам болон үйлчлүүлэгчийн хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа ил тод, нээлттэй, хариуцлагатай байх;

2.1.7. үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах.

Гурав. Нэгдсэн төвөөс үзүүлэх  
үйлчилгээний төрөл

3.1. Нэгдсэн төвөөс үзүүлэх төрийн үйлчилгээ дараах төрөлтэй байна:

3.1.1. өөртөө үзүүлэх үйлчилгээ;

3.1.2. шуурхай үзүүлэх үйлчилгээ;

3.1.3. богино хугацаанд үзүүлэх үйлчилгээ;

3.1.4. урт хугацаанд үзүүлэх үйлчилгээ.

3.2. Өөртөө үзүүлэх үйлчилгээнд үйлчилгээний ажилтны оролцоогүйгээр цахим болон бусад тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглан үйлчлүүлэгч өөрөө бие даан авах боломжтой үйлчилгээ хамаарна.



3.3. Шуурхай үзүүлэх үйлчилгээнд үйлчлүүлэгчийн хүсэлтийг хүлээн авч, шууд (газар дээр нь) шийдвэрлэх боломжтой үйлчилгээ хамаарна.

3.4. Богино хугацаанд үзүүлэх үйлчилгээнд үйлчлүүлэгчийн хүсэлтийг хүлээн авч, ажлын 1 хоногийн дотор шийдвэрлэн хариу өгөх боломжтой үйлчилгээ хамаарна.

3.5. Урт хугацаанд үзүүлэх үйлчилгээнд үйлчлүүлэгчийн хүсэлтийг хүлээн авч, 30 хүртэлх хоногийн дотор шийдвэрлэн хариу өгөх үйлчилгээ хамаарна.


3.6. Энэ журмын 3.1.2-3.1.4-т заасан үйлчилгээний жагсаалт, үйлчилгээний стандартыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, үйлчилгээ үзүүлэх үе шат болон албан хаагчдын эрх, үүргийг тогтоосон хуваарийг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус батална.

3.7. Энэ журмын 3.1-д зааснаас бусад төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн төрийн байгууллага үзүүлнэ.


Дөрөв. Нэгдсэн төвөөс үзүүлэх төрийн үйлчилгээний үе шат

4.1. Нэгдсэн төвөөс үзүүлэх төрийн үйлчилгээний ерөнхий үе шат:


Өөртөө үзүүлэх үйлчилгээний ерөнхий үе шат:



Шуурхай үзүүлэх үйлчилгээний ерөнхий үе шат:



Богино болон урт хугацаанд үзүүлэх үйлчилгээний ерөнхий үе шат:



Тав. Үйлчлүүлэгчийн хүсэлтийг хүлээн авах, бүртгэх журам

5.1. Нэгдсэн төвийн угтах үйлчилгээний ажилтан үйлчлүүлэгчийг угтан хүлээн авч хүсэлтийг нь тодруулан холбогдох мэдээллийг өгч чиглүүлнэ.

5.2. Үйлчлүүлэгч нь нэгдсэн төв дэх үйлчилгээний дугаарын машинаас хэрэгцээт үйлчилгээнийхээ дугаарыг авч, харгалзах цонхонд дарааллын дагуу үйлчлүүлнэ.

5.3. Үйлчилгээний ажилтан дарааллын дагуу үйлчлүүлэгчийг хүлээн авч, хүсэлтийг нь тодруулах бөгөөд баримт бичгийн бүрдлийг шалгаж, үйлчилгээний нэгдсэн системд бүртгэнэ.



5.4. Үйлчлүүлэгчийн хүсэлт энэ журмын 3.1.3, 3.1.4-т хамаарах үйлчилгээ бол хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, үе шат зэрэг мэдээллийг тусгасан бүртгэлийн хуудсыг үйлчлүүлэгчид олгоно.

Зургаа. Үйлчлүүлэгчийн хүсэлтийг буцаах  
нөхцөл

6.1. Нэгдсэн төвийн үйлчилгээний ажилтан дараах тохиолдолд үйлчлүүлэгчид холбогдох зөвлөгөө, мэдээллийг өгч хүсэлтийг нь буцаана:

6.1.1. үйлчилгээний баримт бичгийн бүрдэл болон нөхцөл, шаардлагыг хангаагүй бол;

6.1.2. нэгдсэн төвөөс үзүүлэх үйлчилгээний жагсаалтад хамаарахгүй үйлчилгээ бол;

6.1.3. насанд хүрээгүй иргэн, мөн шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүйд тооцсон, иргэний эрх зүйн чадамжийг нь хязгаарласан этгээд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээрээ төлөөлүүлээгүй бол;

6.1.4. хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

Долоо. Үйлчлүүлэгчийн хүсэлтийг шийдвэрлэх,  
хариу өгөх журам

7.1. Үйлчлүүлэгчийн хүсэлт энэ журмын 3.1.2-т заасан шуурхай үзүүлэх үйлчилгээний төрөлд хамаарч байгаа тохиолдолд үйлчилгээний ажилтан тухайн хүсэлтийг газар дээр нь шууд шийдвэрлэж хариу өгнө.

7.2. Үйлчлүүлэгчийн хүсэлт энэ журмын 3.1.3-т заасан богино хугацаанд үзүүлэх үйлчилгээний төрөлд хамаарч байгаа тохиолдолд үйлчилгээний ажилтан тухайн хүсэлтийг аль болох газар дээр нь шуурхай шийдвэрлэхийг зорих бөгөөд боломжгүй тохиолдолд нэн даруй үйлчилгээний ахлах ажилтан, эсхүл дэмжлэг үзүүлэх ажилтанд шилжүүлнэ.

7.3. Энэ журмын 7.2-т заасан тохиолдолд үйлчилгээний ахлах буюу дэмжлэг үзүүлэх ажилтан тухайн хүсэлтийг хүлээн авч, тогтоосон хугацаанд

багтаан шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, хариуг үйлчилгээний ажилтанд хүргүүлнэ.

7.4. Энэ журмын 7.2, 7.3-т заасан ажиллагаа ажлын 1 хоногоос хэтрэхгүй байна.

7.5. Үйлчлүүлэгчийн хүсэлт энэ журмын 3.1.4-т заасан урт хугацаанд үзүүлэх үйлчилгээний төрөлд хамаарч байгаа тохиолдолд үйлчилгээний ажилтан тухайн хүсэлтийг нэн даруй үйлчилгээний ахлах ажилтан, эсхүл дэмжлэг үзүүлэх ажилтанд шилжүүлнэ.

7.6. Үйлчилгээний ахлах буюу дэмжлэг үзүүлэх ажилтан тухайн хүсэлтийг хүлээн авч, тогтоосон хугацаанд багтаан шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, хариуг үйлчилгээний ажилтанд илгээнэ.

7.7. Энэ журмын 7.5, 7.6-д заасан ажиллагаа 30 хоногоос хэтрэхгүй байна.

7.8. Үйлчилгээний ажилтан нь үйлчлүүлэгчийн хүсэлтийг шийдвэрлэсэн тухай хариуг тухайн байгууллагын хэвлэмэл хуудсаар өгнө.

7.9. Үйлчлүүлэгчийн хүсэлтийг шийдвэрлэж, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, лавлагаа олгох бол үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тусгай нууцлал бүхий үнэт цаасыг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглана.

7.10. Үнэт цаас, хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтыг үйлчилгээний ажилтан хариуцаж, тухайн байгууллага хяналт тавьж ажиллана.

7.11. Үйлчилгээний ажилтан тухайн үйлчлүүлэгчийн хүсэлтийг шийдвэрлэсэн тухай мэдээллийг программд оруулж, энэ тухай үйлчлүүлэгчид цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэн, үйлчлүүлэгч хариутай танилцах боломжийг бүрдүүлснээр хүсэлтийн хариуг өгсөнд тооцно.

7.12. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр хариуг захиалсан хаягаар хүргүүлэх тохиолдолд холбогдох зардлыг тухайн үйлчлүүлэгчээс гаргуулж болно.





Хаягаар хүргэх үйлчилгээний жагсаалт, үйлчилгээний хөлсний хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

### Найм. Гомдол гаргах журам

8.1. Үйлчлүүлэгч нэгдсэн төвийн үйлчилгээний талаарх гомдлыг дараах байгууллага, албан тушаалтанд гаргана:

8.1.1. хүсэлтийг нь хууль тогтоомжийн дагуу үндэслэлтэй, алдаагүй, нэг мөр эцэслэн шийдвэрлээгүй гэж үзвэл гомдлоо үйлчилгээний ахлах ажилтан болон тухайн байгууллагад;

8.1.2. үйлчилгээний стандарт, ажилтны ёс зүйн талаарх гомдлоо нэгдсэн төвийн менежерт;

8.1.3. хүсэлтийг шийдвэрлэх хугацаатай холбогдсон гомдлоо нэгдсэн төвийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнд.

8.2. Энэ журмын 8.1.1-8.1.3-т заасан албан хаагч нь үйлчлүүлэгчийн гаргасан гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэнэ.

### Ес. Нэгдсэн төвөөс үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд тавих хяналт

9.1. Нэгдсэн төвөөс үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд тавих хяналт дараах төрөлтэй байна:

9.1.1. үйлчилгээний чанарын хяналт;

9.1.2. үйлчилгээний стандартын хяналт;

9.1.3. үйлчилгээний хугацааны хяналт.

9.2. Тухайн байгууллага, эсхүл тухайн байгууллагын үйлчилгээний ахлах ажилтан үйлчилгээний хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу үндэслэлтэй, алдаагүй, нэг мөр эцэслэн шийдвэрлэж байгаа эсэхэд энэ журмын 9.1.1-д заасан чанарын хяналт чиглэнэ.



9.3. Нэгдсэн төвийн менежер үйлчилгээг хэвийн, тасралтгүй, шуурхай, стандартын дагуу үзүүлж байгаа эсэхэд энэ журмын 9.1.2-т заасан стандартын хяналт чиглэнэ.

9.4. Нэгдсэн төвийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн үйлчилгээг тогтоосон хугацаанд шийдвэрлэж байгаа эсэхэд энэ журмын 9.1.3-т заасан хугацааны хяналт чиглэнэ.

Арав. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

10.1. Үйлчлүүлэгч дараах эрхтэй:

10.1.1. үйлчилгээний талаар мэдээлэл авах, гомдол гаргах;

10.1.2. холбогдох хууль тогтоомж, стандартад заасан шаардлагыг хангасан үйлчилгээ авах;

10.1.3. энэ журмын 7.12-т заасны дагуу хүсэлтийнхээ хариуг тодорхой хаягаар хүргүүлэх үйлчилгээ авах;

10.1.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

10.2. Үйлчлүүлэгч дараах үүрэгтэй:

10.2.1. үйлчилгээ авахад шаардлагатай баримт бичгийг зохих журмын дагуу бүрдүүлэх, баримт бичгийн үнэн зөвийг хариуцах;

10.2.2. нэгдсэн төвийн үйлчилгээний журмыг дагаж мөрдөх, албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

10.2.3. хүсэлтээ хоёрдмол утгагүй, ойлгомжтой байдлаар гаргах;

10.2.4. үйлчилгээг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан авах бол иргэний хувьд итгэмжлэлээ нотариатаар батлуулсан байх, хуулийн этгээдийн хувьд төлөөлөх эрхээ нотолсон баримт бичигтэй байх.

10.2.5. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.



Арван нэг. Төрийн байгууллагын үүрэг

11.1. Нэгдсэн төвөөр дамжуулан иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага дараах үүрэгтэй:

11.1.1. үйлчлүүлэгчийн хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу аль болох газар дээр нь шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

11.1.2. шаардлагатай тохиолдолд тухайн үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, дүрэм, журамд өөрчлөлт оруулах арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх;

11.1.3. шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх, шинэчлэх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх;

11.1.4. нэгдсэн төвөөр дамжуулан үзүүлэх үйлчилгээний тоо, төрөлд нийцүүлэн үйлчилгээний ажилтны тоог тогтоох, тус төвд ажиллах үйлчилгээний ажилтан болон тухайн байгууллага дээрээ ажиллах дэмжлэг үзүүлэх ажилтнуудын чиг үүргийг хуваарилж, үйлчилгээний шуурхай, тасралтгүй байдлыг хангах;

11.1.5. зөвшөөрөл, лиценз, гэрчилгээ олгоход шаардлагатай баримт бичиг (үнэт цаас, хэвлэмэл хуудас гэх мэт)-ийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

11.1.6. нэгдсэн төвд ажиллаж байгаа ажилтны цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшууллыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу олгож, төвд ажиллах хугацаанд тухайн ажилтны хоол, унааны зардлыг хариуцан ажиллах нөхцөл, баталгаагаар хангах;

11.1.7. нэгдсэн төвөөр дамжуулан үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл (шаардлагатай баримт бичгийн жагсаалт, үйлчилгээ үзүүлэх журам, төлбөр, хураамж болон бусад)-ийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;

11.1.8. нэгдсэн төвөөр дамжуулан үзүүлсэн үйлчилгээний чанарын хяналтыг хариуцан хэрэгжүүлэх;



11.1.9. энэ журмын 3.1.2-3.1.4-т заасан үйлчилгээний үе шат, хугацаа болон үйлчилгээний ажилтан (ахлах ажилтан)-ы чиг үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран тодорхойлж, харилцан уялдаатай ажиллах;

11.1.10. нэгдсэн төвөөс тавьсан хүсэлт, шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг шуурхай авахын зэрэгцээ тус төвд ажиллах албан хаагчдыг тогтмол сургаж, чадавхижуулах арга хэмжээ авах;

11.1.11. хариуцсан салбар, эрх хэмжээнд хамаарах үйлчилгээг хялбаршуулах, шат дамжлагыг цөөлөх, хугацааг богиносгох, цахим архив үүсгэх, үйл ажиллагаандаа дэвшилтэт технологи ашиглах талаар зохих арга хэмжээ авч ажиллах;

11.1.12. нэгдсэн төвөөс ирүүлсэн хүсэлтийг заасан хугацаанд багтаан шуурхай шийдвэрлэж, хариуг тус төвд хүргүүлэх.

11.2. Энэ журмын 11.1-д заасан байгууллагад нэгдсэн төвийн дотоод үйл ажиллагаанд хууль бусаар оролцох, нөлөөлөхийг хориглоно.

Арван хоёр. Үйлчилгээний ажилтны үүрэг

12.1. Нэгдсэн төвийн үйлчилгээний ажилтан дараах үүрэгтэй:

12.1.1. үйл ажиллагаандаа хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн шаардлагыг чанд мөрдөж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;

12.1.2. үйл ажиллагаандаа энэ журам болон бусад дүрэм, журам, заавар, үйлчилгээний зарчим, стандартыг чанд мөрдөх;

12.1.3. үйлчлүүлэгчийг хүндэтгэж, эелдэг, боловсон үйлчлэх;

12.1.4. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Арван гурав. Бусад

13.1. Нэгдсэн төвд ажиллаж байгаа албан хаагчид албан тушаалын цалин хөлсийг тухайн ажилтныг томилсон байгууллага олгоно.



13.2. Нэгдсэн төвд ажиллаж байгаа албан хаагчид урамшуулал олгох, хариуцлага тооцох асуудлыг холбогдох хууль тогтоомж, нэгдсэн төвийн дотоод журмаар зохицуулна.

13.3. Нэгдсэн төв нь төрийн байгууллагуудын мэдээллийн системүүдтэй өгөгдөл солилцох нөхцөлийг хангасан үйлчилгээний нэгдсэн мэдээллийн системтэй байна.

13.4. Нэгдсэн төвөөр дамжуулан үзүүлэх үйлчилгээ нь энэ журмын 13.3-т заасан үйлчилгээний нэгдсэн мэдээллийн системд суурилсан байна.

13.5. Цахим хэлбэрээр мэдээлэл солилцох боломжгүй тохиолдолд тухайн нөхцөл хангагдах хүртэл мэдээллийг (бичгээр) цаасан хэлбэрээр солилцоно.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medelel@parliament.mn](mailto:turiin_medelel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1,75

Индекс: 14003